



**ХЭНГИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 401

Дэлгэрхаан сум

Бүтэц зохион байгуулалт, орон тоо, албан
тушаалын жагсаалт батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Орон тооны жишиг норматив батлах тухай" А/024/11 тоот хамтарсан тушаал, Сургуулийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.3.1, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2026 онд ажиллах багш, ажилтны орон тоо, албан тушаалын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан орон тоонд үндэслэн ажил үүргийн хуваарилалт хийж, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтод тусгаж ажиллахыг сургалтын менежер (Б.Ариунчимэг), нярав (Б.Тогтохжаргал) нарт даалгаж 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ

